



ГАЛТ ТЭРЭГНИЙ
ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН
НЭГДСЭН ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2019 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/42

Улаанбаатар хот

Албан тушаалын тодорхойлолт
шинэчлэн батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2, 48 дугаар зүйлийн 48.3, 48.3.2, Төрийн албаны зөвлөлийн "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах тухай нийтлэг журам батлах тухай" 2019 оны 03 дугаар тогтоол, Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журмын 2.2, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 293 дугаар тушаал, "Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв" улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 6.7.3, 6.9-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "ГТХЗНТ" УТҮГ-ын зохион байгуулалтын бүтэц, ажил албан тушаалын жагсаалт шинэчлэн батлагдсантай холбогдуулан ажилтны албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэст үүрэг болгосугай.


ЗАХИРАЛ



А.БУЯННЭМЭХ

000500

“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв”
улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлын 2019 оны
11 дүгээр сарын 10-ны өдрийн 1/2 дугаар тушаалын
хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах үндэслэл:

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон.

Дагаж мөрдөх огноо:

2019.11.20

Албан тушаалын тодорхойлолт баталсан огноо:

2019.11.20

Байгууллагын нэр

“ГТХЗНТ” УТҮГ

Нэгжийн нэр

Тээврийн нэгдсэн удирдлага,
автоматжуулалт, судалгааны хэлтэс

Албан тушаалын нэр:

Тээврийн нэгдсэн удирдлага,
автоматжуулалт, судалгааны хэлтсийн
дарга

Албан тушаалын ангилал:

Удирдах

Ажлын цаг:

Ажлын өдөр, Найм

Ажлын байрны нөхцөл:

Хэвийн

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн удирдлага, зохицуулалтын бодлого тодорхойлоход дэмжлэг үзүүлэх, шийдвэрлүүлэх, галт тэрэгний хөдөлгөөний удирдлага, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох, суурь бүтэц хоорондын галт тэрэгний хөдөлгөөнийг уялдуулан зохицуулах, Монгол Улсын хэмжээнд дагаж мөрдөх галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулах төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, батлуулах, төмөр замын суурь бүтэц эзэмшигч нарын галт тэрэгний хөдөлгөөнийг нэгдсэн зурмагаар зохицуулах, салбарын автоматжуулалт, технологийн шинэчлэлт, нэгдсэн платформ хөгжүүлэх, төмөр замын сүлжээнд хяналтын систем нэвтрүүлэх, энэ чиглэлээр судалгааны ажил зохион байгуулах, төвийн Захирал, бусад хэрэглэгчдийг шаардлагатай мэдээлэл, мэргэшлийн шуурхай зөвлөгөө, дэмжлэгээр хангах

Албан тушаалын зорилт:

1. Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг боловсруулах, батлуулах, гүйцэтгэлд хяналт тавих, шинжилгээ хийх
2. Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагатай холбоотой санал, дүгнэлт гаргаж шийдвэрлүүлэх
3. Галт тэрэгний хөдөлгөөний удирдлага, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх, санал дүгнэлт гаргах
4. Салбарын автоматжуулалт, технологийн шинэчлэлт, нэгдсэн платформ хөгжүүлэх, төмөр замын сүлжээнд хяналтын систем нэвтрүүлэх, энэ чиглэлээр судалгаа хийх
5. Хөдөлгөөний удирдлага, зохицуулалт, суурь бүтцийн нэвтрүүлэх чадвар, түүний ашиглалт болон тээвэрлэлтийн гүйцэтгэлд дүгнэлт гаргах
6. Суурь бүтэц эзэмшигчийн галт тэрэгний хөдөлгөөн удирдлага, зохицуулалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлага, нэгдсэн технологийн бодлогоор хангах

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Хариуцлага, оролцооны хэлбэр
<p>Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмаг боловсруулах, батлуулах, гүйцэтгэлд хяналт тавих, шинжилгээ хийх гэсэн I зорилтын хүрээнд</p>	<p>1. Төмөр замын суурь бүтцийн техникийн нормчлолын боломжит дээд хэмжээгээр тогтоосон галт тэрэгний бодит хэмжээ бүхий хөдөлгөөний нэгдсэн зурмагийг боловсруулах, батлуулах, суурь бүтэц эзэмшигчид хүргүүлэх.</p> <p>2. Хөдөлгөөний нэгдсэн зурмагийн гүйцэтгэлд хяналт тавих, суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийн тасалдлын мэдээг нэгтгэх, дүн шинжилгээ хийх, тайлан гаргах, хэрэглэгчийг мэдээллээр хангах.</p> <p>3. Хөдөлгөөний нэгдсэн зурмагийн гүйцэтгэлийг сайжруулах, суурь бүтцийн тээх, нэвтрүүлэх чадвар, суурь бүтэц эзэмшигчийн хөдлөх бүрэлдэхүүний ашиглалтад хяналт тавих зорилгоор суурь бүтэц дэх хөдөлгөөний зурмагийн гүйцэтгэлд шинжилгээ хийх</p>	<p>Хариуцан гүйцэтгэх –Г Хянах – Х, Шийдвэрлэх – Ш</p>
<p>Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагатай холбоотой санал, дүгнэлт гаргаж шийдвэрлүүлэх гэсэн II зорилтын хүрээнд</p>	<p>1. Төрийн байгууллага, олон нийтийг хөдөлгөөний нэгдсэн зурмагтай холбоотой зохих мэдээллээр хангаж ажиллах</p> <p>2. Хөдөлгөөний нэгдсэн зурмагт өөрчлөлт оруулах суурь бүтэц эзэмшигчийн саналыг холбогдох журмын хүрээнд хянан шийдвэрлэх</p> <p>3. Төмөр замын тээвэрт гарсан сүйрэл, осол, гологдлын мэдээ мэдээллийг хүлээн авах, холбогдох журмын дагуу төрийн захиргааны төв байгууллагад шуурхай мэдэгдэх, дамжуулах, дүн шинжилгээ хийх</p>	<p>Г, Х, Ш</p>
<p>Галт тэрэгний хөдөлгөөний удирдлага, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх, санал дүгнэлт гаргах гэсэн III зорилтын хүрээнд</p>	<p>1. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогч төмөр замын байгууллагын нэгдсэн технологийн горим, Галт тэрэгний зурмаг зохицуулалтын журам, Төмөр замын тээврийн ашиглалтын ажилд шинжилгээ хийх аргачлал, Төмөр замын ажлын үзүүлэлтүүд, түүнд шинжилгээ хийх аргачлал зэрэг эрх зүйн баримт бичгийг боловсруулах, шинэчлэн сайжруулах, нэмэлт, өөрчлөлтийн санал боловсруулж шийдвэрлүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих</p> <p>2. Дээр дурдсан эрх зүйн баримт бичгийн хийдэл, давхардал, зөрчлийг судлан тогтоох, сайжруулах, боловсронгуй болгох, хууль тогтоомжид нийцүүлэх асуудлаар санал, дүгнэлт гаргаж шийдвэрлүүлэх</p> <p>3. Суурь бүтэц эзэмшигчдийн галт тэрэгний хөдөлгөөнийг нэгдсэн зурмаг, нэгдсэн технологийн горимд нийцүүлэн удирдах, хяналт тавих, үйлчлүүлэгчийн тээвэрлэлтийн эрэлт хэрэгцээг хангах, тэдгээрийн ажлын харилцан уялдаа холбоог сайжруулах, зэргэлдээ төмөр замуудтай галт тэрэг солилцох, хилийн өртөөнд галт тэрэг боловсруулах ажиллагааг хурдасгах ажлыг оновчтой зохион байгуулах</p> <p>4. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтад ашиглаж байгаа өнөөгийн техник, технологийн нөхцөл байдлыг судлан тогтоож, үнэлгээ, дүгнэлт гаргах</p> <p>5. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын дэвшилтэт технологийг харьцуулан судалж тохирох шийдлийн санал боловсруулах</p>	<p>Г, Х, Ш</p>

<p>Салбарын автоматжуулалт, технологийн шинэчлэлт, нэгдсэн платформыг хөгжүүлэх, төмөр замын сүлжээнд хяналтын систем нэвтрүүлэх, энэ чиглэлээр судалгаа хийх гэсэн IY зорилтын хүрээнд</p>	<ol style="list-style-type: none"> 1. Төв болон төмөр замын суурь бүтэц хоорондын техник, технологийн уялдаа холбоог сайжруулах салбарын байгууллагыг арга зүйн удирдлагаар дэмжиж, хамтарч ажиллах 2. Төмөр замын байгууллагаас мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, эдгээрт үндэслэн төвийн үйл ажиллагааг автоматжуулах 3. Суурь бүтцүүдийн хоорондын галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулах, хянах ажиллагааг автоматжуулах чиглэлээр судалгааны ажил зохион байгуулах, орчуулга хийх, санал шийдэл боловсруулах, танилцуулах 4. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн удирдлагын мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, хөгжүүлэх чиглэлээр судалгааны ажил зохион байгуулах, орчуулга хийх, санал шийдэл боловсруулах, танилцуулах 5. Шинээр бий болох суурь бүтцийг галт тэрэгний хөдөлгөөний удирдлага, зохицуулалтын нэгдсэн сүлжээнд холбох тооцоо, судалгааг боловсруулах хэрэгжүүлэх 6. Галт тэрэгний хөдөлгөөний удирдлага зохицуулалтын дэвшилтэт технологийг судлах, турших, нэвтрүүлэх ажлыг төлөвлөж, хэрэгжүүлэх 7. Нэн түрүүнд хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааг тодорхойлж түүнд чиглэсэн төсөл, хөтөлбөр боловсруулан хөрөнгө оруулалт эрэлхийлэх 	<p>Г, Х, Ш</p>
<p>Хөдөлгөөний удирдлага, зохицуулалт, суурь бүтцийн нэвтрүүлэх чадвар, түүний ашиглалт болон тээвэрлэлтийн гүйцэтгэлд дүгнэлт гаргах гэсэн Y зорилтын хүрээнд</p>	<ol style="list-style-type: none"> 1. Хөдөлгөөний нэгдсэн зурмагийн биелэлт болон суурь бүтцийн ашиглалтын ажлын чанарын үзүүлэлтүүдийн биелэлтэд дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах, нэгдсэн зурмагийн гүйцэтгэлийг сайжруулах талаар суурь бүтэц эзэмшигчид албан даалгавар өгч, биелэлтийг хангуулах 2. Суурь бүтцүүдийн техникийн нормчлолын биелэлтэд хяналт тавих 	<p>Г, Х, Ш</p>
<p>Суурь бүтэц эзэмшигчийн галт тэрэгний хөдөлгөөн удирдлага, зохицуулалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлага, нэгдсэн технологийн бодлогоор хангах гэсэн YI зорилтын хүрээнд</p>	<ol style="list-style-type: none"> 3. Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагыг хэрэгжүүлэхэд чиглэсэн суурь бүтэц эзэмшигчийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах 4. Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд суурь бүтцүүдийн хоорондын галт тэрэгний хөдөлгөөнийг захирамжлан зохион байгуулж, зохицуулалт хийх 5. Суурь бүтэц эзэмшигч хоорондын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтын харилцан уялдааг хангах 6. Хилийн боомт, суурь бүтцүүдийн уулзварын өртөөнд галт тэрэг солилцох үйл явцад хяналт тавих 7. Төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосны дагуу төмөр замын салбарын олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг салбарын хэмжээнд зохицуулах, хэрэгжилтийг хангах 	<p>Г, Х, Ш</p>

<p style="text-align: center;">Албан тушаалын зорилтын хүрээнд хийгдэх бусад үйл ажиллагаа</p>	<ol style="list-style-type: none"> 1. Ажилтны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг төвийн хэмжээнд хэвшүүлэх, мөрдүүлэх, ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн тухай гомдол, мэдээллийг холбогдох журмын хүрээнд хянан шийдвэрлэх 2. Ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах, төвийн цахим хуудас хөтлөх, мэдээ мэдээлэл байршуулах, шинэчлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх 3. Зам, тээврийн хөгжлийн сайдын болон захирлын тушаалаар батлагдсан ажлын хэсэг, комисст ажиллах 4. Захирамжлалын болон зохион байгуулалтын, мэдээлэл-лавлагааны баримт бичиг боловсруулах, танилцуулах 5. Тушаал, цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх, тайлагнах 6. Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг тухай бүр гаргах 7. Хариуцсан чиг үүргийн хүрээнд байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлыг тогтоосон хугацаанд судалж шийдвэрлэх 8. Төвийн өдөр тутмын болон олон нийтийн үйл ажиллагаанд оролцох, зохион байгуулах 9. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх, өөрийн харьяалах ажлын байранд тохирсон дүрэм, журмыг боловсруулахад оролцох. 10. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, зохион байгуулах, хяналт тавих, үр дүнг тооцох, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэхэд ажилтнаа манлайлан ажиллах. 11. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд ажил олгогч болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтантай хамтран ажиллах. 	<p style="text-align: center;">Г, Х, Ш</p>
---	---	---

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА	
Боловсрол	Дээд
Мэргэжил	Төмөр замын тээврийн удирдлага, тээвэр зохион байгуулалт
Мэргэшил	Мэргэшсэн инженер, төрийн удирдлагаар мэргэшсэн байх
Туршлага	Салбартаа 5-аас дээш жил ажилласан, удирдах албан тушаалд ажиллаж байсан бол давуу тал
Ур чадвар	<ul style="list-style-type: none"> - Удирдан, зохион байгуулах - Багаар ажиллах - Хариуцлага хүлээх - Бүтээлч, идэвх санаачлагатай - Ажлын ачаалал даах шаардлагатай - Асуудлыг оновчтой шийдвэрлэх - Англи, орос хэлний зохих мэдлэгтэй байх - Баримт бичиг боловсруулах, илтгэх ур чадвартай байх - Харилцааны ёс зүйтэй байх - Компьютер, техник, тоног төхөөрөмж, өргөн хэрэглээний програм ашиглах чадвартай байх

Тусгай шаардлага	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын эрхэм зорилгод хүрэхийн төлөө мэдлэг боловсролоо дайчлан ажиллах - Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахих - Байгууллагын болон хувь хүний нууцыг чанд хадгалах - Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.
------------------	--

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

- Захирал

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо

- Тээврийн нэгдсэн удирдлага, зохицуулалтын ахлах мэргэжилтэн
- Галт тэрэгний хөдөлгөөн, зурмаг зохицуулалтын мэргэжилтэн
- Ашиглалтын ажлын техникийн нормчлол, арга зүйн мэргэжилтэн
- Салбарын судалгаа, олон нийтийн харилцаа хариуцсан ахлах мэргэжилтэн
- Хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
- Салбарын судалгаа, хамтын ажиллагааны мэргэжилтэн

Албан тушаалд шууд бус харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо

- Технологи, автоматжуулалт, судалгаа хариуцсан ахлах мэргэжилтэн
- Технологи, автоматжуулалт, судалгааны мэргэжилтэн
- Олон улсын болон дотоодын төслийн мэргэжилтэн

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаал : Хүний нөөцийн мэргэжилтэн

..... М.ОЮУН-УНДРАМ

Гарын үсэг (Эцэг, эхийн нэр, өөрийн нэр)

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:


Албан тушаал: "ГТХЗНТ" УТҮГ-ын захирал

..... А.БУЯННЭМЭХ

Гарын үсэг (Эцэг, эхийн нэр, өөрийн нэр)



“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв”
улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлын 2019 оны
11 дүгээр сарын 20-ны өдрийн 1/2 дугаар тушаалын
хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах үндэслэл:

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон.

Дагаж мөрдөх огноо:

2019.11.20

Албан тушаалын тодорхойлолт баталсан огноо:

2019.11.20

Байгууллагын нэр

“ГТХЗНТ” УТҮГ

Нэгжийн нэр

Гэрчилгээжүүлэлт, хөдлөх бүрэлдэхүүн
ашиглалт, бүртгэл, мэдээллийн хэлтэс

Албан тушаалын нэр:

Гэрчилгээжүүлэлт, хөдлөх
бүрэлдэхүүн ашиглалт, бүртгэл,
мэдээллийн хэлтсийн дарга

Албан тушаалын ангилал:

Удирдах

Ажлын цаг:

Ажлын өдөр, Найм

Ажлын байрны нөхцөл:

Хэвийн

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Төмөр замын объект, үйл ажиллагаанд гэрчилгээжүүлэлтийн анхан шатны баримт бичгийн иж бүрдэл, гэрчилгээжүүлэлтийн нөхцөл шаардлагыг нягтлан шалгах, бодит, үнэн зөв, шуурхай мэдээллээр хэрэглэгчийг хангах, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн нэгдсэн бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх, бүртгэлийн дугаар, гэрчилгээ олгох үйл ажиллагааг зохион байгуулах, Монгол Улсын хэмжээнд төмөр замын дэд бүтэц хооронд хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн харилцан хуваарилалтад зохицуулалт хийх, хөдлөх бүрэлдэхүүний техникийн үзүүлэлт, оношилгоо, засвар, ашиглалтын талаарх техникийн зохицуулалт, стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, хөдлөх бүрэлдэхүүний техникийн нормчлолын биелэлтэд хяналт тавих, салбарын статистик тайлан, мэдээг улсын хэмжээнд нэгтгэх, дүн шинжилгээ хийх, эрх бүхий байгуулагад хүргүүлэх, хэрэглэгчийг мэдээллээр хангах.

Албан тушаалын зорилт:

1. Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох, хугацааг сунгах баримт бичгийн иж бүрдлийг хангуулах, хүлээн авах, хянах үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах.
2. Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, дугаар, гэрчилгээ олгох үйл ажиллагааг зохион байгуулах.
3. Монгол Улсын хэмжээнд төмөр замын суурь бүтэц хооронд хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн харилцан хуваарилалтад зохицуулалт хийх.
4. Хөдлөх бүрэлдэхүүний техникийн үзүүлэлт, оношилгоо, засвар, ашиглалтын талаарх техникийн зохицуулалт, стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах.
5. Хөдлөх бүрэлдэхүүний техникийн нормчлолын биелэлтэд хяналт тавих

6. Тээвэрлэлтийн статистик тайлан, мэдээг улсын хэмжээнд нэгтгэх, дүн шинжилгээ хийх, эрх бүхий байгуулагад хүргүүлэх

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Хариуцлага, оролцооны хэлбэр
<p>Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох, хугацааг сунгах баримт бичгийн бүрдлийг хангуулах, хүлээн авах, хянах үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах гэсэн I зорилтын хүрээнд</p>	<ol style="list-style-type: none"> 1. Нийтийн болон дагнасан хэрэглээний зам, талбай, өртөө, зөрлөг /төмөр замын дохиолол, холбооны байгууламж/, бүх төрлийн хөдлөх бүрэлдэхүүн /зүтгүүр, ачааны болон зорчигчийн вагон, сэргээн босгох, гал унтраах галт тэрэг, зам засвар, арчлалт, оношлогоо, хэмжилт хийх машин механизм/ гэсэн объектыг гэрчилгээжүүлэх хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, хүсэлтийг хүлээн авах, тухайн объект нь төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэмд заасан тавигдах шаардлагыг хангаж буй эсэх болон баримт бичгийн иж бүрдлийг нягтлан шалгах, гэрчилгээжүүлэлтийн ажлын хэсгийг бодит, үнэн зөв, шуурхай мэдээллээр хангаж ажиллах. 2. Дагнасан хэрэглээний замын дээд, доод бүтцийн засвар, арчлалт болон дагнасан хэрэглээний замд сэлгээний ажил гүйцэтгэх, төмөр замын зураг төсөл боловсруулах, дагнасан хэрэглээний зам, талбай барих, төмөр замын дохиолол, холбооны байгууламжийн техникийн, зүтгүүрийн болон вагоны техникийн үзлэг, үйлчилгээ гүйцэтгэх, төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхлэх, хатуу тооцоот багаж, хэрэгслийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх үйл ажиллагааг гэрчилгээжүүлэх хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, хүсэлтийг хүлээн авах, тухайн үйл ажиллагаа нь төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэмд заасан тавигдах шаардлагыг хангаж буй эсэх болон баримт бичгийн иж бүрдлийг нягтлан шалгах, гэрчилгээжүүлэлтийн ажлын хэсгийг бодит, үнэн зөв, шуурхай мэдээллээр хангаж ажиллах. 3. Гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн сан бүрдүүлэх, хөтлөх, хэрэглэгчдийг үнэн зөв, бодит мэдээллээр хангах. 	<p>Хариуцан гүйцэтгэх –Г Хянах – Х, Шийдвэрлэх - Ш</p>

<p>Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, дугаар, гэрчилгээ олгох үйл ажиллагааг зохион байгуулах гэсэн II зорилтын хүрээнд</p>	<ol style="list-style-type: none"> 1. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлт, шийдвэрийг үндэслэн хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийг Улсын бүртгэлд бүртгэх, дугаар, гэрчилгээ олгох, иргэн, хуулийн этгээдийг мэдээллээр хангах ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулах. 2. Хөдлөх бүрэлдэхүүний өмчлөл, эзэмшил өөрчлөгдсөн тохиолдолд Улсын нэгдсэн бүртгэлээс хасах, шинээр бүртгэх ажлыг зохион байгуулах. 3. Суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгч байгууллагаас Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний талаарх шаардлагатай бүртгэл, мэдээ, тайланг тухай бүрт нь шуурхай, цахим хэлбэрээр болон албан бичгээр авч, нэгтгэн мэдээллийн сан бүрдүүлж, хөтлөх, хэрэглэгчийг мэдээллээр хангах. 4. Хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч нарт холбогдох стандарт, журмын хүрээнд өмчлөгчийн код олгох, мэдээлэх. 5. Улсын хэмжээнд хөдлөх бүрэлдэхүүний нэгдсэн тооллого, бүртгэлийг 2 жил тутамд зохион байгуулах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, холбогдох мэдээ мэдээллээр хэрэглэгчийг хангах. 	<p>Г, Х, Ш</p>
<p>Монгол Улсын хэмжээнд төмөр замын суурь бүтэц хооронд хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн харилцан хуваарилалтад зохицуулалт хийх гэсэн III зорилтын хүрээнд</p>	<ol style="list-style-type: none"> 1. Хилийн боомт, суурь бүтцүүдийн уулзварын өртөөнд галт тэрэг солилцох гүйцэтгэлд хяналт тавих, галт тэрэг солилцох үйл ажиллагааны технологийг боловсруулах. 2. Суурь бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, тээвэрлэгчийн ашиглагдаж байгаа болон нөөцөд шаардлагатай, хөдлөх бүрэлдэхүүний парк ашиглалтын тайлан, судалгааг улирал бүр, жилээр гаргуулан авах, тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулан хяналт тавих. 	<p>Г, Х, Ш</p>
<p>Хөдлөх бүрэлдэхүүний техникийн үзүүлэлт, оношилгоо, засвар, ашиглалтын талаарх техникийн зохицуулалт, стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах гэсэн IV зорилтын хүрээнд</p>	<ol style="list-style-type: none"> 1. Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журмын хэрэгжилтэд эрх, чиг үүргийн хүрээнд хяналт тавьж ажиллах. 2. Монгол Улсын хилийн боомтын төмөр замын хилийн өртөөгөөр нэвтрүүлэх хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх үйл ажиллагаа төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэмд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах, дүгнэлт, зөвлөмж гаргах, хүргүүлэх. 3. Төмөр замын тээврийн хүртээмжтэй байдлыг хангах, тээвэрлэгч, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлгийн оператор, тээвэр зуучлагчийн тэгш оролцоог хангуулах. 	<p>Г, Х, Ш</p>

<p>Суурь бүтэц эзэмшигчийн галт тэрэгний хөдөлгөөн удирдлага, зохицуулалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлага, нэгдсэн технологийн бодлогоор хангах гэсэн ҮИ зорилтын хүрээнд</p>	<p>3. Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагыг хэрэгжүүлэхэд чиглэсэн суурь бүтэц эзэмшигчийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах</p> <p>4. Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд суурь бүтцүүдийн хоорондын галт тэрэгний хөдөлгөөнийг захирамжлан зохион байгуулж, зохицуулалт хийх</p> <p>5. Суурь бүтэц эзэмшигч хоорондын хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтын харилцан уялдааг хангах</p> <p>6. Хилийн боомт, суурь бүтцүүдийн уулзварын өртөөнд галт тэрэг солилцох үйл явцад хяналт тавих</p> <p>7. Төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосны дагуу төмөр замын салбарын олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг салбарын хэмжээнд зохицуулах, хэрэгжилтийг хангах</p> <p>8. Төмөр замын тээврийн бодлого боловсронгуй болгох талаар санал боловсруулах, Төмөр замын тээврийн бодлогыг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэхэд төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах</p>	<p>Г, Х, Ш</p>
--	--	-----------------------

<p>Хөдлөх бүрэлдэхүүний техникийн нормчлолын биелэлтэд хяналт тавих гэсэн Ү зорилтын хүрээнд</p>	<ol style="list-style-type: none"> 1. Монгол Улсын хилээр нэвтэрч буй галт тэрэгний бүрэлдэхүүний бүдүүвчид техникийн болон тээвэрлэлтийн нөхцөлөөс хамааран өөрчлөлт оруулах тухай суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн эзэмшигч, тээвэрлэгч нарын хүсэлтийг судалж холбогдох байгууллагад саналаа хүргүүлэх. 2. Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний хийцэд орсон өөрчлөлтийг мэдээллийн санд бүртгэх, гэрчилгээнд тэмдэглэл хийх, мэдэгдэх. 3. Хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэг ашиглалтын бүртгэл, хяналтыг болон салбар замын бүртгэлийг цахимжуулах. 	<p>Г, Х, Ш</p>
<p>Тээвэрлэлтийн статистик тайлан, мэдээг улсын хэмжээнд нэгтгэх, дүн шинжилгээ хийх, эрх бүхий байгуулагад хүргүүлэх гэсэн Ү зорилтын хүрээнд</p>	<ol style="list-style-type: none"> 1. Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээллийн сан бүрдүүлж, хөтлөх, ашиглах үйл ажиллагааг төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэмд заасны дагуу зохион байгуулах, хэрэгжүүлэх. 2. Салбарын статистик мэдээ тайланд дүн шинжилгээ хийх, эрх бүхий байгуулагад хүргүүлэх, хэрэглэгчийг бодит, үнэн зөв, шуурхай мэдээллээр хангах. 3. Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмын хоёрдугаар хавсралтад заасан маягтын дагуу холбогдох баталгаажсан, үнэн зөв статистик мэдээллийг төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Үндэсний статистикийн хороонд хүргүүлэх. 4. Дээрх журамд заасан мэдээлэл болон салбарын мэдээллийн санг бүрдүүлэхэд шаардлагатай мэдээллийг төмөр замын байгууллагуудаас гаргуулах. 5. Статистик мэдээ мэдээлэлд дүн шинжилгээ хийх, ачаа, ачаа эргэлт, зорчигч тээвэрлэлт, зорчигч эргэлт зэрэг мэдээллийг олон нийтэд тогтмол мэдээлэх. 6. Төмөр замын байгууллагуудын мэдээлэл солилцох тогтолцоог боловсронгуй болгох, хөгжүүлэх, энэ чиглэлээр төсөл, судалгааны ажил гүйцэтгэж, хэрэгжүүлэх, нэвтрүүлэх 7. Төвийн техник, технологи, автоматжуулалт, мэдээллийн тасралтгүй, найдвартай, аюулгүй байдлыг хангах. 	<p>Г, Х, Ш</p>
<p>Албан тушаалын зорилтын хүрээнд хийгдэх бусад үйл ажиллагаа</p>	<ol style="list-style-type: none"> 1. Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект, үйл ажиллагаанд шинжилгээ хийж тохирлын үнэлгээ гаргах, захиалагчийн хүсэлтээр тохирлын үнэлгээний гэрчилгээ олгох ажлыг судалж, холбогдох эрх зүйн бичиг баримтыг бүрдүүлж, хэрэгжүүлж ажиллах. 2. Суурь бүтцүүдийн хэмжээнд тээврийн үйл ажиллагаанд ашиглах радио зурвасыг эзэмших, ашиглах, хуваарилах ажлыг судалж, холбогдох эрх зүйн бичиг баримтыг бүрдүүлж, хэрэгжүүлж ажиллах. 3. Өвөлжилтийн бэлтгэлийг хангах арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлж ажиллах, хяналт тавих, салбарын төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтоосон хугацаанд төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, тайлагнах. 4. Ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд үйл ажиллагааны ил тод байдлыг хэрэгжилтийг хангах. 	<p>Г, Х, Ш</p>

	<p>5. Зам, тээврийн хөгжлийн сайдын болон захирлын тушаалаар батлагдсан ажлын хэсэг, комисст ажиллах.</p> <p>6. Захирамжлалын болон зохион байгуулалтын, мэдээлэл-лавлагааны баримт бичиг боловсруулах, танилцуулах.</p> <p>7. Тушаал, цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх, тайлагнах.</p> <p>8. Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг тухай бүр гаргах.</p> <p>9. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх, өөрийн харьяалах ажлын байранд тохирсон дүрэм, журмыг боловсруулахад оролцох.</p> <p>10. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, зохион байгуулах, хяналт тавих, үр дүнг тооцох, удирдлагын тогтолцоог нэвтрүүлэхэд ажилтнаа манлайлан ажиллах.</p> <p>11. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд ажил олгогч болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтантай хамтран ажиллах.</p> <p>12. Хариуцсан чиг үүргийн хүрээнд байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлыг тогтоосон хугацаанд судалж шийдвэрлэх.</p> <p>13. Төвийн өдөр тутмын болон олон нийтийн үйл ажиллагаанд оролцох, зохион байгуулах.</p>	
--	---	--

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Дээд
Мэргэжил	Вагон, вагоны аж ахуйн инженер
Мэргэшил	
Туршлага	Салбартаа 5-аас дээш жил ажилласан байх
Ур чадвар	<ul style="list-style-type: none"> - Удирдан, зохион байгуулах - Багаар ажиллах - Хариуцлага хүлээх - Бүтээлч, идэвх санаачлагатай - Ажлын ачаалал даах шаардлагатай - Асуудлыг оновчтой шийдвэрлэх - Англи, орос хэлний зохих мэдлэгтэй байх - Баримт бичиг боловсруулах, илтгэх ур чадвартай байх - Харилцааны ёс зүйтэй байх - Компьютер, техник, тоног төхөөрөмж, өргөн хэрэглээний програм ашиглах чадвартай байх
Тусгай шаардлага	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын эрхэм зорилгод хүрэхийн төлөө мэдлэг боловсролоо дайчлан ажиллах - Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахих - Байгууллагын болон хувь хүний нууцыг чанд хадгалах - Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

- Захирал

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо

- Суурь бүтэц ашиглалт, объектын гэрчилгээжүүлэлт хариуцсан ахлах мэргэжилтэн
- Хөдлөх бүрэлдэхүүн ашиглалт, чингэлэг бүртгэлийн мэргэжилтэн
- Тээвэр зуучлалын бүртгэл, стандартчиллын мэргэжилтэн
- Статистик мэдээлэл, тээвэрлэлтийн үйл ажиллагааны гэрчилгээжүүлэлт хариуцсан ахлах мэргэжилтэн
- Статистик мэдээллийн сан, гэрчилгээжүүлэлтийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн
- Гэрчилгээжүүлэлтийн бүртгэл, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
- Програм хангамж, радио зурвас, сүлжээ хариуцсан мэргэжилтэн

Албан тушаалд шууд бус харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо

- Технологи, автоматжуулалт, судалгаа хариуцсан ахлах мэргэжилтэн
- Технологи, автоматжуулалт, судалгааны мэргэжилтэн
- Олон улсын болон дотоодын төслийн мэргэжилтэн

У. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаал: Хүний нөөцийн мэргэжилтэн

 М.ОЮУН-УНДРАМ

Гарын үсэг (Эцэг, эхийн нэр, өөрийн нэр)

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:


Албан тушаал "БТХЗНТ" УТҮГ-ын Захирал

 А.БУЯННЭМЭХ

Гарын үсэг (Эцэг, эхийн нэр, өөрийн нэр)



“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв”
улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлын 2019 оны
11 дүгээр сарын 20-ны өдрийн 1/2 дугаар тушаалын
хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах үндэслэл:

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон.

Дагаж мөрдөх огноо:

2019.11.20

Албан тушаалын тодорхойлолт баталсан огноо:

2019.11.20

Байгууллагын нэр

“ГТХЗНТ” УТҮГ

Нэгжийн нэр

Гэрчилгээжүүлэлт, Хөдлөх бүрэлдэхүүн
ашиглалт, бүртгэл, мэдээллийн хэлтэс

Албан тушаалын нэр:

Статистик, мэдээлэл, тээвэрлэлтийн
үйл ажиллагааны гэрчилгээжүүлэлт
хариуцсан ахлах мэргэжилтэн

Албан тушаалын ангилал:

Гүйцэтгэх

Ажлын цаг:

Ажлын өдөр, Найм

Ажлын байрны нөхцөл:

Хэвийн

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

МУ-ын статистикийн хууль тогтоомж, “Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам”-ын хэрэгжилтийг хангах.

Төмөр замын тээвэрлэлтийн аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагааны гэрчилгээ олгох, хугацааг сунгахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, энэ чиглэлээр салбарын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх.

Хариуцсан багийн ажлыг зохион байгуулах.

Албан тушаалын зорилт:

1. Төмөр замын салбарын статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийх, цахимжуулах бодлогыг хэрэгжүүлэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх.
2. Төмөр замын салбарын бүртгэл, статистикийн талаар гаргасан хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход оролцох, иргэн, хуулийн этгээд, төрийн захиргааны төв байгууллагыг шаардлагатай статистик мэдээллээр хангах, мэдээллийн үнэн зөв байдлыг бүрэн хариуцаж ажиллах.
3. Төмөр замын тээвэрлэлтийн аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагааны гэрчилгээ олгох, хугацааг сунгахтай холбоотой ажлыг зохион байгуулах.
4. Хариуцсан багийн ажлыг төвийн дүрэм журам, төлөвлөгөөний дагуу үр дүнтэй удирдах, манлайлах

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Хариуцлага, оролцооны хэлбэр
1 дүгээр зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none"> 1. Төмөр замын салбарын жил, хагас жил, улирал, сар, хоногийн мэдээнд дүн шинжилгээ хийх; 2. Статистик мэдээллийг ашиглан тоон болон чанарын үзүүлэлтийг тооцож, тайлагнах. 3. Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, цахимжуулах ажлыг зохион байгуулах 	Гүйцэтгэх-Г, Хянах-Х, Шийдвэрлэх-Ш, Дэмжлэг үзүүлэх-Д
2 дугаар зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none"> 1. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Үндэсний статистикийн хороонд батлагдсан маягтын дагуу статистик мэдээллийг хүргүүлэх; 2. “Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам”-ын хүрээнд мэдээллийг төвийн цахим хуудсанд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар байршуулах ажлыг зохион байгуулах. 3. Монгол улсын нэгдэн орсон олон улсын байгууллага, холбооны үйл ажиллагаанд оролцсон тухай мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх 4. Статистикийн болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг сурталчлан таниулах, боловсронгуй болгохоор чиглэлээр санал боловсруулж, шийдвэрлүүлж ажиллах 5. Статистик бүртгэл мэдээллийн чиглэлээр олон улсын туршлага судлах, сайн туршлагыг нутагшуулах, салбарын хэмжээнд сурталчлах, 6. Төмөр замын тээвэрлэлтийн аюулгүй байдалтай холбоотой үйл ажиллагааны гэрчилгээжүүлэлт олгох, хугацаа сунгахтай холбоотой бичиг баримтын бүрдүүлэлтийг шалгах. 7. Гэрчилгээжүүлэлттэй холбоотой баримт бичгийг архивын нэгж болгон хадгалах, хадгалалтад хяналт тавих 8. Гэрчилгээжүүлэлттэй холбоотой мэдээ, мэдээллээр төрийн захиргааны төв байгууллага болон төвийн удирдлагыг хангах, сурталчлах 9. Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагуудаас гэрчилгээжүүлэлттэй холбоотой төрийн үйлчилгээний талаар санал судалгаа авах, шийдвэрлүүлэх 	Г, Д
3 дугаар зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none"> 1. Багийн ажлыг шуурхай удирдлагаар хангах, гаргасан шийдвэртээ тууштай байх, багийн гишүүд болон удирдлагын өмнө хариуцлага хүлээх чадвартай байх. 2. Багийн ажлын төлөвлөгөөг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд уялдуулан гаргах. 3. Багийн ажлыг дүгнэж тайлагнах, багийн гишүүдэд ажил үүргийг жигд хуваарилах, тэгш оролцоог хангах. 4. Багийн гишүүдийн ажлыг бодитой үнэлэх, гүйцэтгэлийг хянах, урамшуулж, идэвхижүүлж байх 	Г, Ш, Д

Албан тушаалын зорилтын хүрээнд хийгдэх бусад үйл ажиллагаа	<p>1. Сайдын болон Захирлын тушаалаар батлагдсан ажлын хэсэг, комисст ажиллах;</p> <p>2. Тушаал, албан бичиг, зөвлөмж, дүгнэлт, дүрэм, журам, тайлан, тэмдэглэл, удирдамж, төлөвлөгөө, тодорхойлолт, мэдээлэл, санал, танилцуулга зэрэг захирамжлалын, зохион байгуулалтын, мэдээлэл-лавлагааны баримт бичиг боловсруулах, танилцуулах;</p> <p>3. Тушаал, цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх, тайлагнах;</p> <p>4. Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг тухай бүр гаргаж өгөх, тайлагнах;</p> <p>5. Хариуцсан чиг үүргийн дагуу байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлыг тогтоосон хугацаанд судалж шийдвэрлэх;</p> <p>6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, өдөр тутмын зааваарчилгааны дагуу ажиллах.</p> <p>7. Үүрэгт ажилтай холбоотой баримт бичиг, албан хэргийг холбогдох хууль, дүрэм, журам, стандартын дагуу хөтлөн явуулж, үүсгэсэн баримт бичиг, холбогдох материалыг архивын дүрэм, журмын дагуу үдэж цэгцлэн тогтоосон хугацаанд архивт хүлээлгэн өгөх;</p> <p>8. Төвийн өдөр тутмын болон олон нийтийн үйл ажиллагаанд оролцох, зохион байгуулах.</p>	Г
--	---	----------

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Дээд
Мэргэжил	Төмөр замын инженер тээврийн удирдлагын менежмент, статистикч,
Мэргэшил	Статистикч
Туршлага	Мэргэжлээрээ 3-с дээш жил ажилласан байх
Ур чадвар	<ul style="list-style-type: none"> - Орос, Англи хэлний мэдлэгтэй, - Удирдан зохион байгуулах, - Асуудлыг оновчтой шийдвэрлэх, - Багаар ажиллах, хариуцлага хүлээх, - Бүтээлч идэвх санаачлагатай, - Харилцааны ёс зүйтэй, - Баримт нотолгоонд тулгуурласан тооцоолол хийх чадвартай, - Компьютер, техник, тоног төхөөрөмж, - Өргөн хэрэглээний програм дээр ажиллах чадвартай байх.
Тусгай шаардлага	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын эрхэм зорилгод хүрэхийн төлөө мэдлэг боловсролоо дайчлан ажиллах. - Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахих. - Байгууллагын болон хувь хүний нууцыг чанд хадгалах. - Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
- Гэрчилгээжүүлэлт, хөдлөх бүрэлдэхүүн ашиглалт, бүртгэл, мэдээллийн хэлтсийн дарга
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо
- Статистик мэдээллийн сан, гэрчилгээжүүлэлтийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн
- Гэрчилгээжүүлэлтийн бүртгэл, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ


Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:


Албан тушаал: Хүний нөөцийн мэргэжилтэн


.....М.Ожун-Ундрaм
Гарын үсэг (Эцэг, эхийн нэр, өөрийн нэр)

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Албан тушаал: "ГТХЗНГ" УТҮГ-ын захирал


.....А.Буяннэмэх
Гарын үсэг (Эцэг, эхийн нэр, өөрийн нэр)



“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв”
улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлын 2019 оны
11 дүгээр сарын 20-ны өдрийн 42 дугаар тушаалын
хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ 70225

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах үндэслэл:

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон.

Дагаж мөрдөх огноо:

2019.11.20

Албан тушаалын тодорхойлолт баталсан огноо:

2019.11.20

Байгууллагын нэр

“ГТХЗНТ” УТҮГ

Нэгжийн нэр

Гэрчилгээжүүлэлт, хөдлөх бүрэлдэхүүн
ашиглалт, бүртгэл мэдээллийн хэлтэс

Албан тушаалын нэр:

Суурь бүтэц ашиглалт, объектийн
гэрчилгээжүүлэлт хариуцсан ахлах
мэргэжилтэн

Албан тушаалын ангилал:

Гүйцэтгэх

Ажлын цаг:

Ажлын өдөр, Найм

Ажлын байрны нөхцөл:

Хэвийн

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Суурь бүтэц эзэмшигчидийн замын аж ахуйн чиглэлээр харилцан уялдаа, хамтын ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах,

Суурь бүтцийн объектийг гэрчилгээжүүлэлттэй холбоотой ажлыг зохион байгуулах, энэ чиглэлээр салбарын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх,

Хариуцсан багийн ажлыг зохион байгуулах,

Албан тушаалын зорилт:

1. Суурь бүтцүүдийн замын аж ахуйн чиглэлээрх дүрэм, журмын хэрэгжилтэд судалгаа хийх, дүгнэлт, тайлан гаргах, замын аж ахуйн чиглэлээрх мэдээлэл, гэрчилгээжүүлэлтийг салбарын нэгдсэн мэдээллийн санд бүртгэх, хасах, өөрчлөлт оруулах
2. Төмөр замын салбарт шаардлагатай гадаад орны стандарт, норм норматив, судалгааны ажил орчуулан боловсруулах, Монгол Улсад нутагшуулах ажлыг зохион байгуулалтаар хангах ажиллах;
3. Хариуцсан багийн ажлыг төвийн дүрэм журам, төлөвлөгөөний дагуу үр дүнтэй удирдах, манлайлах

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Хариуцлага, оролцооны хэлбэр
--------	------------------------------------	------------------------------

<p>1 дүгээр зорилтын хүрээнд</p>	<ol style="list-style-type: none"> 1. Суурь бүтэц, салбар зам бүртгэх, дугаар олгох талаар холбогдох журмын хэрэгжилтийг хангуулах, гэрчилгээ олгох, цахимжуулах. 2. Төмөр замын тээврийн хүртээмжтэй байдлыг хянах, тээвэрлэгч, хөдлөх бүрэлдэхүүн, чингэлэгийн оператор, тээвэр зуучлагчийн тэгш оролцоог хангуулах талаар санал дүгнэлт гаргах. 3. Монгол улсын төмөр замын суурь бүтцүүдийн гэрчилгээжүүлэлтийн бүртгэлийг хөтлөх, объектийн мэдээллийн сан бүрдүүлж, мэдээллийг боловсруулах, хянах, хадгалах, зохицуулах. 4. Салбарын суурь бүтцийн сүлжээ, түүний доорх газрын эзэмшлийг бүртгэх, гэрчилгээжүүлэх, төмөр замын хөгжлийн төлөвлөлтөд санал, дүгнэлт гаргах, арга зүйгээр хангах. 5. Суурь бүтцүүдийн замын аж ахуйн чиглэлийн тоног төхөөрөмж, замын машин механизм, хиймэл төхөөрөмжийн ашиглалтанд дүн шинжилгээ хийж, санал боловсруулж хэлэлцүүлэх, шийдвэрлүүлэх. 6. Суурь бүтэц эзэмшигчидийн болон тээврийн үйл ажиллагаанд оролцогчдыг нэгдсэн технологийн процессд уялдуулах талаар санал дүгнэлт боловсруулах. 7. Шинээр баригдах төмөр замын бүтээн байгуулалт, төсөл хөтөлбөрийн эдийн засгийн үр ашгийн үнэлгээ, тооцоо гаргах ажлын хэсэгт ажиллах. 8. Суурь бүтцүүдийн замын хөгжлийн төлөвлөлт, шинэ техник, технологи нэвтрүүлэх талаар санал, дүгнэлт гаргах. 9. Суурь бүтэцтэй холбогдолтой хийгдсэн судалгааны ажлыг боловсронгуй болгох талаар санал, зөвлөмж гаргах. 10. Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагуудаас объект гэрчилгээжүүлэлттэй холбоотой төрийн үйлчилгээний талаар санал судалгаа авах, шийдвэрлүүлэх. 	<p>Гүйцэтгэх-Г, Хянах-Х, Шийдвэрлэх-Ш, Дэмжлэг үзүүлэх-Д</p>
<p>2 дугаар зорилтын хүрээнд</p>	<ol style="list-style-type: none"> 1. Төмөр замын тээврийн салбарын стандарт, норм, нормативыг хөгжүүлэх, хэрэгжүүлэх талаар судалгаа хийх, 2. Тохирлын үнэлгээний итгэмжлэгдсэн байгууллага болох үйл ажиллагааг хариуцах 3. Шинээр боловсруулан нутагшуулах стандартын судалгаа хийх 4. Стандарт орчуулан боловсруулах, батлуулах ажлын хүрээнд салбарын яам, албан байгууллага, дэд бүтцийн салбар нэгжүүдтэй хамтран ажиллах үйл ажиллагааг зохион байгуулах 5. Стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавих, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хэрэглэгчдийг мэдээ, мэдээллээр хангах; 	<p>Г, Д</p>

<p>3 дугаар зорилтын хүрээн</p>	<p>1. Багийн ажлыг шуурхай удирдлагаар хангах, гаргасан шийдвэртээ тууштай байх, багийн гишүүд болон удирдлагын өмнө хариуцлага хүлээх чадвартай байх.</p> <p>2. Багийн ажлын төлөвлөгөөг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд уялдуулан гаргах.</p> <p>3. Багийн ажлыг дүгнэж тайлагнах, багийн гишүүдэд ажил үүргийг жигд хуваарилах, тэгш оролцоог хангах.</p> <p>4. Багийн гишүүдийн ажлыг бодитой үнэлэх, гүйцэтгэлийг хянах, урамшуулж, идэвхижүүлж байх.</p>	<p>Г,Ш</p>
<p>Албан тушаалын зорилтын хүрээнд хийгдэх бусад үйл ажиллагаа</p>	<p>1. Сайдын болон Захирлын тушаалаар батлагдсан ажлын хэсэг, комисст ажиллах.</p> <p>2. Тушаал, албан бичиг, зөвлөмж, дүгнэлт, дүрэм, журам, тайлан, тэмдэглэл, удирдамж, төлөвлөгөө, тодорхойлолт, мэдээлэл, санал, танилцуулга зэрэг захирамжлалын, зохион байгуулалтын, мэдээлэл-лавлагааны баримт бичиг боловсруулах, танилцуулах.</p> <p>3. Тушаал, цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх, тайлагнах.</p> <p>4. Шаардлагатай үед албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг тухай бүр гаргаж өгөх, тайлагнах.</p> <p>5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, өдөр тутмын зааваарчилгааны дагуу ажиллах.</p> <p>6. Хариуцсан чиг үүргийн дагуу байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлыг тогтоосон хугацаанд судалж шийдвэрлэх.</p> <p>7. Үүрэгт ажилтай холбоотой баримт бичиг, албан хэргийг холбогдох хууль, дүрэм, журам, стандартын дагуу хөтлөн явуулж, үүсгэсэн баримт бичиг, холбогдох материалыг архивын дүрэм, журмын дагуу үдэж цэгцлэн тогтоосон хугацаанд архивт хүлээлгэн өгөх.</p> <p>8. Төвийн өдөр тутмын болон олон нийтийн үйл ажиллагаанд оролцох, зохион байгуулах.</p>	<p>Г,Д</p>

<p>III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА</p>	
<p>Боловсрол</p>	<p>Дээд</p>
<p>Мэргэжил</p>	<p>Төмөр замын зам, замын аж ахуй, зүтгүүр, вагон, дохиолол холбооны инженер</p>
<p>Мэргэшил</p>	<p>Төмөр замын мэргэшсэн инженер байх</p>
<p>Туршлага</p>	<p>Мэргэжлээрээ 5-с дээш жил ажилласан байх</p>
<p>Ур чадвар</p>	<ul style="list-style-type: none"> - Орос, Англи, Хятад аль нэг хэлний мэдлэгтэй, - Удирдан зохион байгуулах, - Асуудлыг оновчтой шийдвэрлэх, - Багаар ажиллах, - Хариуцлага хүлээх, - Бүтээлч идэвх санаачлагатай, - Харилцааны ёс зүйтэй, - Компьютер, техник, тоног төхөөрөмж, өргөн хэрэглээний програм дээр ажиллах чадвартай байх.
<p>Тусгай шаардлага</p>	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын эрхэм зорилгод хүрэхийн төлөө мэдлэг боловсролоо дайчлан ажиллах; - Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахих; - Байгууллагын болон хувь хүний нууцыг чанд хадгалах, - Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

- Гэрчилгээжүүлэлт, хөдлөх бүрэлдэхүүн ашиглалт, бүртгэл мэдээллийн хэлтсийн дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо

1. Хөдлөх бүрэлдэхүүн ашиглалт, чингэлэг бүртгэлийн мэргэжилтэн
2. Тээвэр зуучлалын бүртгэл, стандартчилалын мэргэжилтэн
3. Програм хангамж, радио зурвас, сүлжээ хариуцсан мэргэжилтэн

Нийт 3

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаал: Хүний нөөцийн мэргэжилтэн

..... М.Оюун-Ундрэм
Гарын үсэг (Эцэг, эхийн нэр, өөрийн нэр)


Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Албан тушаал: "ГТХЗНТ" УТҮГ-ын захирал

..... А.Буяннэмэх
Гарын үсэг (Эцэг, эхийн нэр, өөрийн нэр)



“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв”
улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлын 2019 оны
11 дүгээр сарын 10-ны өдрийн 1/2 дугаар тушаалын
хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах үндэслэл:

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон.

Дагаж мөрдөх огноо:

2019.11.20

Албан тушаалын тодорхойлолт баталсан огноо:

2019.11.20

Байгууллагын нэр

“ГТХЗНТ” УТҮГ

Нэгжийн нэр

Гэрчилгээжүүлэлт, хөдлөх бүрэлдэхүүн
ашиглалт, бүртгэл мэдээллийн хэлтэс

Албан тушаалын нэр:

Тээвэр зуучлалын бүртгэл,
стандартчилалын мэргэжилтэн

Албан тушаалын ангилал:

Гүйцэтгэх

Ажлын цаг:

Ажлын өдөр, Найм

Ажлын байрны нөхцөл:

Хэвийн

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

- Тээвэр зуучлагчийн тэгш оролцоог хангуулах, салбарын нэгдсэн мэдээллийн санд бүртгэх, төмөр замын тээврийн логистикийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх талаар санал санаачлага гаргах,
- Салбарын хэмжээний шаардлагатай стандартын сан бүрдүүлэх

Албан тушаалын зорилт:

- Тээвэр зуучын байгууллагуудыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх, мэдээллийн сан бүрдүүлэх, гэрчилгээ, тохирлын үнэлгээ олгох, төмөр замын тээврийн хүртээмжтэй байдлыг цахимаар хянах, тээвэрлэгч, чингэлгийн оператор, тээвэр зуучлагчийн тэгш оролцоог бий болгох ажлыг судлах, дүгнэлт гаргах.
- Тээвэр зуучлал, логистикийн үйл ажиллагааны талаар мөрдөгдөж буй дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавих, олон улсын стандарт, шинэ техник, технологи, арга барилыг нэвтрүүлэх судалгаа хийх ажлыг зохион байгуулах.
- Салбарын хэмжээний стандарт норм, нормативыг орчуулах, боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулалтаар хангах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Хариуцлага, оролцооны хэлбэр
--------	------------------------------------	------------------------------

<p>1 дүгээр зорилтын хүрээнд</p>	<p>1. Тээвэр зуучын гэрчилгээ олгох, сунгах, цуцлах, бүртгэх, бүртгэлээс хасах, гэрчилгээжүүлэх талаар санал гаргах, шийдвэрлүүлэх.</p> <p>2. Салбарын хэмжээнд төмөр замын тээвэрлэлтэд оролцож буй тээвэр зуучийн тэгш оролцоог хангуулах талаар санал, судалгаа авах, дүгнэлт гаргах.</p> <p>3. Тээвэр зуучийн бүртгэл хяналтыг цахимжуулах талаар судалгаа хийх, санал гаргах, хэрэгжүүлэх.</p> <p>4. Тээвэр зуучлагчдын холбоодтой нягт хамтран ажиллах.</p>	<p>Гүйцэтгэх-Г, Хянах-Х, Шийдвэрлэх-Ш, Дэмжлэг үзүүлэх-Д</p>
<p>2 дугаар зорилтын хүрээнд</p>	<p>1. Тээвэр зуучлал, логистикийн талаар салбарын хэмжээнд мөрдөгдөж буй дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд хяналт тавих, судлах, санал дүгнэлт гаргах.</p> <p>2. Тээвэр зуучлагч байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар ажил зохион байгуулах, олон улсын туршлага нэврүүлэх талаар судалгаа хийх.</p> <p>3. Тээвэрлэлтийн салбар хоорондын уялдаа холбоог зохицуулах, логистикийн үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх талаар судалгаа, шинжилгээ хийх, дүгнэлт, санал зөвлөмж боловсруулах.</p> <p>4. Монгол улсын өнөөгийн тээвэр логистикийн нөхцөл байдлыг судлан шинжлэх санал зөвлөмж боловсруулах.</p>	<p>Г, Д</p>
<p>3 дугаар зорилтын хүрээнд</p>	<p>1. Төмөр замын тээвэрлэлттэй холбоотой стандарт, норм норматив шинээр орчуулан боловсруулах.</p> <p>2. Стандарт, норм нормативийг хянуулах, батлуулах ажлыг зохион байгуулах.</p> <p>3. Салбарын стандартын нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх.</p> <p>4. Тохирлын үнэлгээ олгох чиглэлээр судлагаа хийх, санал дүгнэлт гаргах, хэлэлцүүлэх.</p>	<p>Г, Д</p>
<p>Албан тушаалын зорилтын хүрээнд хийгдэх бусад үйл ажиллагаа</p>	<p>1. Сайдын болон Захирлын тушаалаар батлагдсан ажлын хэсэг, комисст ажиллах</p> <p>2. Тушаал, албан бичиг, зөвлөмж, дүгнэлт, дүрэм, журам, тайлан, тэмдэглэл, удирдамж, төлөвлөгөө, тодорхойлолт, мэдээлэл, санал, танилцуулга зэрэг захирамжлалын, зохион байгуулалтын, мэдээлэл-лавлагааны баримт бичиг боловсруулах, танилцуулах</p> <p>3. Тушаал, цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх, тайлагнах</p> <p>4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, өдөр тутмын зааваарчилгааны дагуу ажиллах.</p> <p>5. Хариуцсан чиг үүргийн дагуу байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлыг тогтоосон хугацаанд судалж шийдвэрлэх</p> <p>6. Үүрэгт ажилтай холбоотой баримт бичиг, албан хэргийг холбогдох хууль, дүрэм, журам, стандартын дагуу хөтлөн явуулж, үүсгэсэн баримт бичиг, холбогдох материалыг архивын дүрэм, журмын дагуу үдэж цэгцлэн тогтоосон хугацаанд архивт хүлээлгэн өгөх</p> <p>7. Төвийн өдөр тутмын болон олон нийтийн үйл ажиллагаанд оролцох, зохион байгуулах.</p>	<p>Г,</p>


III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА	
Боловсрол	Дээд
Мэргэжил	Төмөр замын инженер, тээврийн удирдлагын менежмент
Мэргэшил	
Туршлага	Мэргэжлээрээ 1-с дээш жил ажилласан байх
Ур чадвар	<ul style="list-style-type: none"> - Орос, Англи, Хятад аль нэг хэлний мэдлэгтэй, - Удирдан зохион байгуулах, - Асуудлыг оновчтой шийдвэрлэх, - Багаар ажиллах, - Хариуцлага хүлээх, - Бүтээлч идэвх санаачлагатай, - Харилцааны ёс зүйтэй, - Компьютер, техник, тоног төхөөрөмж, өргөн хэрэглээний програм дээр ажиллах чадвартай байх.
Тусгай шаардлага	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын эрхэм зорилгод хүрэхийн төлөө мэдлэг боловсролоо дайчлан ажиллах; - Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахих; - Байгууллагын болон хувь хүний нууцыг чанд хадгалах, - Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ
Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: <ul style="list-style-type: none"> - Гэрчилгээжүүлэлт, хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт, бүртгэл, мэдээллийн хэлтсийн дарга - Суурь бүтэц ашиглалт, объектийн гэрчилгээжүүлэлт хариуцсан ахлах мэргэжилтэн
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:
Албан тушаал: Хүний нөөцийн мэргэжилтэн	Албан тушаал: "ТТХЗНТ" УТҮГ-ын захирал
.....М.Оюун-УндрэмА.Буяннэмэх
Гарын үсэг (Эцэг, эхийн нэр, өөрийн нэр)	Гарын үсэг (Эцэг, эхийн нэр, өөрийн нэр)



“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв”
улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлын 2019 оны
11 дүгээр сарын 22-ны өдрийн 462 дугаар тушаалын
хавсралт



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах үндэслэл:

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон.

Дагаж мөрдөх огноо:

2019.11.20

Албан тушаалын тодорхойлолт баталсан огноо:

2019.11.20

Байгууллагын нэр

“ГТХЗНТ” УТҮГ

Нэгжийн нэр

Гэрчилгээжүүлэлт, хөдлөх бүрэлдэхүүн
ашиглалт, бүртгэл, мэдээллийн хэлтэс

Албан тушаалын нэр:

Статистик мэдээллийн сан,
гэрчилгээжүүлэлтийн бүртгэл
хариуцсан мэргэжилтэн

Албан тушаалын ангилал:

Гүйцэтгэх

Ажлын цаг:

Ажлын өдөр, Найм

Ажлын байрны нөхцөл:

Хэвийн

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

МУ-ын статистикийн тухай хууль тогтоомж, “Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллах зорилгын хүрээнд Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээллийг цуглуулах, боловсруулах, хөтлөх, ашиглах, хадгалах

Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагааны болон объектийн гэрчилгээжүүлэлт бүртгэлийн програм хангамжийн аюулгүй байдал, хөгжүүлэлтийг хангах

Албан тушаалын зорилт:

